



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 4/127

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын "Дээд боловсролын тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, МУИС-ийн Дүрмийн 4.5.8.3, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж, дэмжигдсэн "МУИС-ийн шагнал, урамшууллын нийтлэг журам"-ыг хавсралтаар баталж, 2017 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.


2. Журам батлагдсантай холбогдуулан захирлын 2003 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 727 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "МУИС-ийн шилдэг багш шалгаруулах журам", 2 дугаар хавсралтаар батлагдсан "Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулах журам", 2012 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн Б/497 дугаар тушаалаар батлагдсан "Эрдмийн элч медалиар шагнах журам"-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Батлагдсан журмыг сургуулийн цахим хуудсанд байршуулан, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, дотоод хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал (Ч.Ундрам)-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Я.ТӨМӨРБААТАР



Захирлын 2017 оны дугаар сарын 18-ны
өдрийн А/127 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ШАГНАЛ, УРАМШУУЛЛЫН НИЙТЛЭГ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухааны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан, МУИС-ийн хөгжил, Стратеги төлөвлөгөөний биелэлтэд онцгой үүрэг гүйцэтгэсэн багш, ажилтан, оюутан, хамтран ажилладаг хувь хүн, байгууллагыг нэгдсэн бодлого, шалгуур үзүүлэлт, зохион байгуулалтын дагуу шагнал урамшуулалд нэр дэвшүүлэх, шалгаруулах, шагнал урамшууллыг олгож алдаршуулах ажиллагааг зохицуулахад оршино.

1.2 МУИС-ийн шагнал, урамшууллын журам нь МУИС-ийн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд хэрэгжинэ.

1.3 МУИС-ийн багш, ажилтан, оюутан, хамтран ажиллагч хувь хүн, байгууллагыг Монгол Улсын цол хүртээх, Төрийн одон медаль, Засгийн газрын шагналд тодорхойлж нэр дэвшүүлэх болон Монгол Улсын Их Сургуулийн шагналаар шагнах, урамшуулал олгох, алдаршуулахад энэхүү журмыг мөрдөнө.

ХОЁР. МУИС-ИЙН ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

2.1 МУИС-ийн шагнал, урамшуулал нь дараах төрөлтэй байна. Үүнд:

2.1.1 МУИС-ийн багш, их сургуульд багшилж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хүнд дараах шагнал, урамшууллыг олгож болно.

- "Эрдмийн элч" медаль
- МУИС-ийн Хүндэт дэвтэрт нэрийг нь бичиж алдаршуулах
- Захирлын нэрэмжит шагнал
- Шилдэг зохиогч
- Шилдэг оюуны өмч бүтээгч
- Оны шилдэг багш
- "Хүндэт жуух"
- "Баярын бичиг"

2.1.2 МУИС-ийн захиргааны ажилтан, үйлчилгээний ажилчид, тус их сургуульд энэ чиглэлийн ажил эрхэлж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэнд дараах шагнал, урамшууллыг олгож болно.

- Хүндэт дэвтэрт нэрийг нь бичиж алдаршуулах
- "Хүндэт жуух"
- "Баярын бичиг"
- Оны шилдэг захиргааны ажилтан
- Оны шилдэг үйлчилгээний ажилтан

2.1.3 МУИС-ийн оюутан, төгсөгчдөд дараах шагнал, урамшууллыг олгож

болно.

- "Хүндэт жуух"
- "Баярын бичиг"
- Шилдэг төгсөгч
- Оны шилдэг диссертаци
- Онцлох оюутан
- Оны шилдэг оюутан



2.1.4 МУИС-тай хамтран ажилладаг хувь хүн, байгууллагад дараах шагнал, урамшууллыг олгож болно.

- "Хүндэт жуух"
- "Баярын бичиг"
- Онцгой түнш өргөмжлөл
- Шилдэг түнш өргөмжлөл

2.1.5 Өндөр насны тэтгэвэр тогтоолгох, Хөдөлмөрийн алдар тэмдэглэх зэрэг багш, ажилтантай холбоотой тэмдэглэлт үйл явдлын үеэр бүрэлдэхүүн сургууль болон харьяалах алба нь "Өргөмжлөл", "Дурсамж" хадгалуулж болно.

2.1.6 Үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа онцгой амжилт гаргасан багш, ажилтанд бүрэлдэхүүн сургуулийн захирал, алба хэлтсийн дарга нар үндсэн цалингийн 100 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний цалингийн урамшуулал олгож болно.

ГУРАВ. ШАГНАЛ, УРАМШУУЛЛЫН БОЛЗОЛ, ШАЛГУУР

3.1 Нийтлэг болзол, шалгуур

Шагнал, урамшуулалд нэр дэвшигч нь хамт олноо манлайлан, их сургууль болон шинжлэх ухаан, технологи, боловсролын салбарыг хөгжүүлэх үйлсэд идэвх санаачлага, үр бүтээлтэй ажиллаж, эрхэлж буй ажилдаа тодорхой амжилт гаргасан, сахилгын болон ёс зүйн зөрчил гаргаагүй байна.

3.2 Тусгай болзол, шалгуур

Шагнал урамшуулалд нэр дэвшигч нь 3.1-д заасан нийтлэг шалгуураас гадна нэр дэвшиж буй шагнал, урамшуулалын тусгай болзол, шалгуурыг хангасан байна.

3.2.1 **Монгол Улсын цол, Төрийн одон медаль, Засгийн газрын шагналд** нэр дэвшигч нь тухайн шагналтай холбоотой харилцааг зохицуулах журамд заасан болзол, шалгуурыг бүрэн хангасан байна.

3.2.2 **"Эрдмийн элч"** медальд нэр дэвшигч нь Монгол Улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухааны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан, судалгаа, шинжилгээний бүтээл туурвисан, их сургуулийн хөгжил, дэвшилд онцгой үүрэг гүйцэтгэсэн Монгол Улсын болон гадаадын иргэн байна.

3.2.3 **"Хүндэт дэвтэрт нэрийг нь бичиж алдаршуулах"** шагналд нэр дэвшигч нь МУИС-д 30-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж, их сургуулийн хөгжил, дэвшилд онцгой үүрэг гүйцэтгэсэн багш, ажилтан байна.

3.2.4 **"Хүндэт жуух"**-д нэр дэвшигч нь хариуцаж буй ажлын чиг үүрэгтэй холбоотой стратеги төлөвлөгөөний зорилт, гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийг ханган биелүүлэхэд үр бүтээлтэй 6-аас доошгүй жил ажилласан багш, ажилтан; сурлага, урлаг спортын амжилтаараа тэргүүний, олон нийтийн ажилд идэвхтэй оролцогч оюутан, 3-аас доошгүй жил амжилттай хамтран ажилласан түншлэгч байгууллага, хувь хүн байна.

3.2.5 **"Баярын бичиг"**-т нэр дэвшигч нь эрхэлж буй ажилдаа тодорхой

амжилт гаргасан, их сургуульд 3-аас доошгүй жил ажилласан багш, ажилтан, сурлага, урлаг спортын амжилтаараа тэргүүний, олон нийтийн ажилд идэвхтэй оролцогч оюутан; 2-оос доошгүй жил амжилттай хамтран ажилласан түншлэгч байгууллага, хувь хүн байна.

3.2.6 **"Захирлын нэрэмжит шагнал", "Шилдэг зохиогч"** шагналд нэр дэвшигч нь тухайн хичээлийн жилд WEB OF SCIENCE мэдээллийн санд бүртгэлтэй олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн багш, ажилтан байна.

"Шилдэг зохиогч"-ийг Нэгдүгээр зохиогч, Холбоо барих зохиогч, Хамтран зохиогч гэсэн номинациар шалгаруулна.

3.2.7 **"Шилдэг оюуны өмч бүтээгч"** шагналд нэр дэвшигч нь тухайн хичээлийн жилд МУИС-ийн нэр дээр оюуны өмч бүртгүүлсэн багш, ажилтан байна.

3.2.8 **"Оны шилдэг багш"**-ийг "Оны шилдэг багш", "Оны шилдэг судлаач багш", "Оны шилдэг залуу багш" гэсэн номинациар байгалийн ухаан, нийгэм-хүмүүнлэгийн ухааны салбар тус бүрээр шалгаруулах бөгөөд нэр дэвшигч нь дараах болзол, шалгуурыг хангасан байна.

3.2.8.1 **"Оны шилдэг багш"**-д нэр дэвшигч нь МУИС-д 15-аас доошгүй жил тасралтгүй ажиллаж, сургалтанд шинэ арга, технологи нэвтрүүлэн ажилладаг, сургалт, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэж байгаа үндсэн багш байна.

3.2.8.2 **"Оны шилдэг судлаач багш"**-д нэр дэвшигч нь МУИС-ийн нэрээр эрдэм шинжилгээний бүтээл туурвиж, тухайн жилд импакт фактор бүхий олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн, эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлдэг үндсэн багш байна.

3.2.8.3 **"Оны шилдэг залуу багш"**-д нэр дэвшигч нь МУИС-д 5-аас доошгүй жил багшилсан, 35 хүртэл насны үндсэн багш байна.

3.2.9 **"Оны шилдэг захиргааны ажилтан"**-д нэр дэвшигч нь МУИС-ийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг ханган биелүүлэх, их сургуулийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр шинэ ажил санаачлан, амжилттай хэрэгжүүлсэн үндсэн ажилтан байна.

3.2.10 **"Оны шилдэг үйлчилгээний ажилтан"**-д нэр дэвшигч нь хариуцсан ажлаа хариуцлагатай, чанартай гүйцэтгэдэг, хамт олны дунд нэр хүндтэй үндсэн ажилтан байна.

3.2.11 **"Оны шилдэг диссертаци"**-д нэр дэвшиж буй бүтээл нь судалгааны ажлын зорилтоо бүрэн хангаж, шинэлэг, дэвшилтэт санаа, дүгнэлтийг гаргасан, үр дүнг нь тухайн шинжлэх ухааны салбарт ашиглах боломжтой, эдийн засаг, нийгэм, технологийн ач холбогдол бүхий бүтээл байна.

3.2.12 **"Онцлох оюутан"**-д нэр дэвшигч нь МУИС-ийг төлөөлөн Олон улсын хэмжээний олимпиад, оюуны уралдаан тэмцээн, урлаг, спортын наадамд оролцож, эхний 3 байранд шалгарсан, 2-оос доошгүй улирал амжилттай суралцаж буй оюутан байна.

3.2.13 **"Оны шилдэг оюутан"**-д нэр дэвшигч нь 2-оос доошгүй улирал амжилттай суралцаж байгаа, тухайн жилд МУИС-ийг төлөөлөн урлаг, спорт, олон нийтийн ажилд идэвхтэй оролцож, сурлага, урлаг, спортын өндөр амжилт үзүүлсэн шилдэг оюутан байна.

3.2.14 **"Шилдэг төгсөгч"**-д нэр дэвшигч нь дэлхий дахинд Монгол улсын нэр хүндийг өндөрт өргөн сурталчилж, тус улсын улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжилд онцгой хувь нэмэр оруулсан төр, нийгэм, үндэстний өмнө онцгой гавъяа байгуулсан

МУИС-ийн төгсөгч байна.

3.2.15 "Онцлох түнш"-д нэр дэвшигч нь МУИС-ийн хөгжилд том хэмжээний оюуны болон материаллаг хувь нэмэр оруулсан гадаад, дотоодын байгууллага, хувь хүн байж болно.

3.2.16 "Шилдэг түнш"-д нэр дэвшигч нь МУИС-тай тогтвортой, найдвартай хамтран ажиллагч, их сургуулийн сургалт, судалгааны үйл ажиллагаанд оюуны болон материаллаг хувь нэмэр оруулсан гадаад, дотоодын байгууллага, хувь хүн байж болно.

ДӨРӨВ. ШАГНАЛ, УРАМШУУЛАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОДОРХОИЛОХ

4.1 Багш нарын баяр, Шинжлэх ухаан, соёлын ажилтны өдөр, бусад мэргэжлийн болон тэмдэглэлт ойн баяр, МУИС, бүрэлдэхүүн сургууль, тэнхмийн ойгоор бүрэлдэхүүн сургууль болон нэгжээс шагнал, урамшуулалын шалгуурыг бүрэн хангасан, МУИС-д ажиллаж байгаа багш, ажилтан, сурч байгаа оюутан, төгсөгч болон МУИС-иас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад настан, хамтран ажиллагч байгууллага, хувь хүнийг холбогдох шагнал, урамшуулалд нэр дэвшүүлнэ.

4.2 Шагнал, урамшуулалд нэр дэвшүүлэх багш, ажилтан, оюутан, хамтран ажиллагч байгууллага, хувь хүнийг холбогдох нэгжийн хамт олны хурал, бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэр гаргана. Хамт олны хурлын ирц 75%-иас доошгүй байх шаардлагатай ба хуралд оролцогчдын 80-аас дээш хувь нь дэмжсэн тохиолдолд шагнал, урамшуулалд нэр дэвшүүлсэнд тооцож, тодорхойлолт гаргана.

4.3 Шагнал, урамшуулалд нэр дэвшүүлэх багш, ажилтны ажил байдлын тодорхойлолтод нийт ажилласан хугацааны ажлын амжилт, үр бүтээл, оруулсан хувь нэмэр, төрийн албан хаагчийн ёс зүйн байдал, ажил мэргэжлийн үр чадварын талаар үнэн зөв, тодорхой бичих ба бүтээлийн жагсаалт зэрэг холбогдох баримт бичгийг хавсаргасан байна.

4.4 Шагнал, урамшуулалд нэр дэвшүүлэх оюутны тодорхойлолтод суралцах хугацаанд гаргасан сурлага, урлаг, спортын амжилт, суралцагчийн ёс зүйн байдлын талаар үнэн, зөв, тодорхой бичиж, холбогдох баримт бичгийг хавсаргасан байна.

4.5 Шагнал, урамшуулалд нэр дэвшүүлэх хамтран ажиллагч байгууллага, хувь хүмүүсийн хувьд хамтран ажиллуулах хугацаанд их сургуулийн оруулсан оюуны болон материаллаг хувь нэмэр, хамтын ажиллагааны үр дүнгийн талаар үнэн, зөв тодорхой бичиж, холбогдох баримт бичгийг хавсаргасан байна.

4.6 Монгол Улсын цол, Төрийн одон медаль, Засгийн газрын шагналд нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолтод МУИС-ийн захирал бүтээлийн жагсаалтад бүрэлдэхүүн сургуулийн дэд захирал, МУИС-ийн шагнал, урамшуулалд нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолтод бүрэлдэхүүн сургуулийн захирал, холбогдох нэгжийн удирдлага гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулна.


4.7 МУИС-ийн шагнал, урамшууллын хоорондын зай 3-аас доошгүй жил байна. МУИС-ийн шагнал, урамшууллыг давхардуулан олгохгүй. Энэхүү заалт нь захирлын нэрэмжит шагнал, шилдэг зохиогч, шилдэг оюуны өмч бүтээгч шагналд хамаарахгүй.

4.8 Шагнуулахаар нэр дэвшүүлж буй хүмүүс дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ. "Захирлын нэрэмжит шагнал", "Шилдэг зохиогч" шалгаруулалтад нэр дэвшигч нь баримт бичиг бүрдүүлэхгүй байж болно.

4.8.1 Монгол Улсын цол, Төрийн одон медаль, Засгийн газрын шагнал, МУИС-ийн шагналаар шагнуулахаар нэр дэвшигчид дараах баримт бичгийг

бүрдүүлнэ.

- Анкет /Монгол Улсын цол, Төрийн одон медаль, Засгийн газрын шагналд нэр дэвшигчид холбогдох журамд заасан анкетыг бөглөнө./
- Хамт олны хурлын тэмдэглэл
- Бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийн хурлын тэмдэглэл
- Ажил байдлын тодорхойлолт
- Бүтээлийн жагсаалт
- Өмнөх шагналын хуулбар



4.8.2 **Дээд шагнал “Эрдмийн элч” медаль-д** нэр дэвшүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

- Нэр дэвшигчийн танилцуулга /Хавсралт 1/
- Хийсэн ажлын үр дүн, шинэ нээлт, шинэ санаа, үзэл баримтлал, МУИС-ийн болон шинжлэх ухааны хөгжилд оруулсан хувь нэмрийг нотлох баримт
- Хамт олны хурлын шийдвэр

4.8.3 **“Хүндэт дэвтэрт нэрийг нь бичиж алдаршуулах”** шагналд нэр дэвшүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

- Нэр дэвшигчийн танилцуулга /Хавсралт 1/
- Хамт олны хурлын шийдвэр
- Шагнал олгох үндэслэл, тайлбар танилцуулга
- Хүндэт дэвтэрт бичих хүндэтгэлийн үг

4.8.4 **“Шилдэг оюуны өмч бүтээгч”** шагналд нэр дэвшигч дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

- Нэр дэвшигчийн танилцуулга /Хавсралт 1/
- Бүтээсэн оюуны өмчийн бүртгэлийн хуулбар
- Бүтээсэн оюуны өмчийн дэлгэрэнгүй танилцуулга

4.8.5 **“Оны шилдэг багш”-д** нэр дэвшигч дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

- Нэр дэвшигчийн танилцуулга /Хавсралт 1/
- Хамт олны хурлын тэмдэглэл
- Сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлын тэмдэглэл
- Бүтээлийн үзэсгэлэнд тавих биет материал /хэвлүүлсэн өгүүлэл, бичсэн ном, сурах бичиг, гарын авлага, хичээлийн үзүүлэн зэрэг бусад холбогдох материал/
- Багш, оюутны дунд хийсэн санал асуулгын дүн

4.8.6 **“Оны шилдэг ажилтан”-д** нэр дэвшигч дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

- Нэр дэвшигчийн танилцуулга /Хавсралт 1/
- Хамт олны хурлын тэмдэглэл
- Тухайн жилд гаргасан амжилт, гүйцэтгэсэн ажлын тайлан, үр дүн
- Шууд харъяалах удирдлагын тодорхойлолт

4.8.7 **“Оны шилдэг диссертаци”-д** нэр дэвшигч дараах материалыг бүрдүүлнэ.

- Суралцагчийн товч танилцуулга
- Удирдагч багшийн тодорхойлолт
- Диссертаци
- Хамгаалуулах зөвлөлийн хурлын тогтоол

4.8.8 "Онцлох оюутан", "Оны шилдэг оюутан" шагналд нэр дэвшигч дараах материалыг бүрдүүлнэ.

- Оюутны сурлагын дүнгийн баталгаажсан тодорхойлолт
- Оюутны талаарх зөвлөх профессор/тэнхмийн эрхлэгчийн тодорхойлолт
- Гаргасан амжилтыг илтгэх баримт бичгийн хуулбар

4.8.9 "Шилдэг төгсөгч" шагналын болзол, шалгуурыг хангасан иргэнийг бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн санал болгосноор Захиргаа, хүний нөөцийн алба судалж, захиралд танилцуулна

4.8.10 "Онцлох түнш", "Шилдэг түнш" шагналд нэр дэвшүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

- Тухайн байгууллага, хувь хүнтэй хамтран ажиллаж буй нэгжийн санал, дүгнэлт
- Бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр
- Хамтын ажиллагааны бодит үр дүн, үр нөлөөг илтгэх баримт бичиг

ТАВ. ШАГНАЛ, УРАМШУУЛЛЫГ ШИЙДВЭРЛЭХ, ОЛГОХ

5.1 Монгол Улсын цол, Төрийн одон медаль, Засгийн газрын шагнал, МУИС-ийн шагнал, урамшуулалд нэр дэвшигчдийн бүрдүүлбэл зохих баримт бичгийн бүрдүүлэлтэнд тэнхмийн эрхлэгч хяналт тавьж, харъяалах сургуулийн захиргааны зөвлөл/эрдмийн зөвлөлөөр хэлэлцэнэ.

5.2 Шагнал, урамшуулалд нэр дэвшүүлэх санал, холбогдох баримт бичгийг тэмдэглэлт ой, баярын өдөр болохоос 1 сараас доошгүй хугацааны өмнө Захиргаа, хүний нөөцийн албанд ирүүлнэ.

5.3 Шагнал, урамшуулалд нэр дэвшигчдийн баримт бичгийг хүлээн авсан, хүлээлгэн өгсөн тухай Захиргаа, хүний нөөцийн албаны хүний нөөцийн мэргэжилтэн болон хүлээлгэн өгсөн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

5.4 Захиргаа, хүний нөөцийн алба нь шагнал, урамшуулалд нэр дэвшигчтэй холбоотой материалыг шалгаж, шалгаруулах ажлын хэсгийг байгуулах тушаалын төслийг ажлын 5 хоногийн дотор боловсруулж батлуулна.

5.5 МУИС-ийн дээд шагнал Эрдмийн элч медалиар шагнуулах, МУИС-ийн хүндэт дэвтэрт нэрийг нь бичиж алдаршуулахаар ирүүлсэн нэр дэвшигчдийн баримт бичгийг Захиргаа, хүний нөөцийн албанаас МУИС-ийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

5.6 МУИС-ийн захирлын нэрэмжит шагнал, Шилдэг зохиогч, Шилдэг оюуны өмч бүтээгч, Оны шилдэг диссертацийн шалгаруулалтыг Эрдэм шинжилгээ, инновац, гадаад харилцаа хариуцсан дэд захирлаар ахлуулсан ажлын хэсэг шийдвэрлэнэ.

5.7 Оны шилдэг суралцагч, Онцлох оюутанд нэр дэвшигчдийн шалгаруулалтыг Сургалт, оюутан хариуцсан дэд захирлаар ахлуулсан ажлын хэсэг шийдвэрлэнэ.

5.8 Монгол Улсын цол, Төрийн одон медаль, Засгийн газрын шагнал, МУИС-ийн оны шилдэг багш, шилдэг ажилтан, онцлох түнш, шилдэг түнш шагнал болон Хүндэт жуух, Баярын бичгээр шагнуулахаар ирүүлсэн нэр дэвшигчдийн шалгаруулалтыг Захиргаа, дотоод хамтын ажиллагаа хариуцсан дэд захирлаар ахлуулсан ажлын хэсэг шийдвэрлэнэ.

5.9 Ажлын хэсэг нь МУИС-ийн шагнал, урамшуулалд нэр дэвшигч нь нэр дэвшиж буй шагнал, урамшууллын болзлыг хангаж байгаа эсэхийг шалгаж, шагнуулах багш, ажилтныг шалгаруулах үүрэгтэй.

5.10 Захиргаа, хүний нөөцийн алба нь ажлын хэсгийн дүгнэлт, саналыг үндэслэн Монгол Улсын цол, Төрийн одон медаль, Засгийн газрын шагналд нэр дэвшигчдийн баримт бичгийг эцэслэн бэлтгэж, хууль тогтоомжид заасан хугацаанд багтаан холбогдох байгууллагад хүргүүлэн, эргэх холбоотой ажиллана

5.11 МУИС-ийн шагнал, урамшууллыг үндсэн нэгжийн санал, ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн Захирлын тушаалаар олгоно.

5.12 Энэхүү журмын дагуу шагнал, урамшуулалд тодорхойлогдож, шагнагдсан багш, ажилтанд шагналд дагалдах мөнгөн урамшууллыг олгоно

5.13 Шагнал урамшуулалд дагалдан гарах мөнгөн урамшууллын зардлыг харъяалах нэгжийн шагнал, урамшууллын зардлаас санхүүжүүлнэ.

5.14 Шагналд дагалдах мөнгөн урамшуулал дараах хэмжээтэй байна.

А. Төрийн дээд болон Засгийн газрын шагнал:

Хөдөлмөрийн баатар цол	500.000₮
Ардын цол	400.000₮
Төрийн шагнал	300.000₮
Гавьяат цол	250.000₮
Төрийн одон	200.000₮
Төрийн медаль	150.000₮
Засгийн газрын шагнал /тэргүүний ажилтан/	100.000₮

Б. МУИС-ийн шагнал, урамшуулал:

Эрдмийн элч медаль	3.500.000₮
МУИС-ийн захирлын нэрэмжит шагнал	3.000.000₮
Хүндэт дэвтэрт нэрийг нь бичиж алдаршуулах	500.000₮
Хүндэт жуух	50.000₮
Баярын бичиг	30.000₮
Шилдэг зохиогч :	
Нэгдүгээр зохиогч /өгүүлэл тус бүр/	500.000₮
Холбоо барих зохиогч /өгүүлэл тус бүр/	400.000₮
Хамтран зохиогч /өгүүлэл тус бүр/	200.000₮
Шилдэг оюуны өмч бүтээгч	500.000₮
Оны шилдэг багш, /Оны шилдэг судлаач багш	багшийн зэрэглэлийн 1 сарын үндсэн цалин
Оны шилдэг залуу багш	1.000.000₮
Оны шилдэг ажилтан	1 сарын үндсэн цалин
Онцлох оюутан	5 багц цагийн үнэлгээ
Оны шилдэг оюутан	3 багц цагийн үнэлгээ

5.15 Оны шилдэг диссертацид шалгарсан бүтээлийг МУИС-ийн зардлаар "Шилдэг диссертаци" гэсэн хавтастайгаар 3 хувь хэвлүүлж, 1 хувийг сургуулийн номын сангийн хүндэтгэлийн хэсэгт байрлуулж, нэг хувийг холбогдох тэнхимд өгнө. Шилдэг диссертацийн эзэнд "Өргөмжлөл"-ийг диссертацийн хамт Төгсөлтийн баярын үеэр гардуулна.


5.16 Шилдэг төгсөгчийн шагнал олгох иргэнд "Шилдэг төгсөгч" медаль олгох бөгөөд шагналыг Төгсөлтийн баярын үеэр ёслол төгөлдөр гардуулж, "Өргөмжлөл" хадгалуулна.

5.17 Онцлох түнш шагналаар шагнуулах байгууллага, хувь хүнд "МУИС-ийн онцлох түнш" тэмдэг гардуулж, нэрийг нь Алдрын самбарт бичиж алдаршуулна.

5.18 Шилдэг түнш шагналаар шагнуулах байгууллага хувь хүнд "МУИС-ийн шилдэг түншлэгч" тэмдэг гардуулж, "Өргөмжлөл" олгоно.

5.19 МУИС-ийн шагнал, урамшуулалд нэр дэвшин, шагнагдсан хүмүүсийн бүрдүүлсэн баримт бичгийг буцаан олгохгүй, архивын нэгж болгон хадгална.

5.20 Захиргаа, хүний нөөцийн алба нь МУИС-ийн хэмжээнд шагнагдсан болон шагнуулахаар нэр дэвшигдэж байсан багш, ажилтан, оюутан, төгсөгч, түншлэгчийн нэгдсэн мэдээллийн сантай байна.



-0000-

МУИС-ИЙН ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ АЖИЛТНЫ ТАНИЛЦУУЛГА

1. Ургийн овог
2. Эцэг, эхийн нэр
3. Өөрийн нэр
4. Регистрийн дугаар
5. Нас, хүйс
6. Яс, үндэс
7. Үндсэн захиргаа

8. Боловсрол

Д/д	Төгссөн сургууль	Суралцсан хугацаа	Эзэмшсэн боловсрол, мэргэжил
1			
2			
3			

9. Ажил эрхэлсэн байдал /он дарааллаар/

Д/д	Ажлын газрын нэр	Ажилласан хугацаа /он сараар/	Эрхэлсэн ажил албан тушаал
1			
2			

10. Нийт ажилласан жил:

- Үүнээс: Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт:
- Тухайн хамт олон дотор ажилласан жил:

11. Шагнагдаж байсан шагналууд /оны дараалал баримтлан бичих бөгөөд Яамны бусад шагналаар шагнагдсан бол түүний хуулбарыг заавал хавсаргана/

Д/д	Шагналын нэр	Шагнагдсан он
1		
2		

12. Шагнуулах үндэслэл. /Товч, тодорхой бичнэ/

13. Тухайн ажилтны ажил мэргэжлийн ур чадвар, үйл ажиллагаа, мэргэшлийн түвшиний үнэлгээ /сүүлийн 5 жилээр/

14. Ямар шагналд нэр дэвшүүлж буй санал:

15. Хамт олны саналын хувь:

16. Байгууллагын холбоо барих утас, ажилтны нэр:

“Оны шилдэг багш”-д нэр дэвшигчийн ажлыг үнэлэх шалгуур үзүүлэлт

№	Шалгаруулах болзол	Үнэлгээ
1	Бичиж оюутны хүртээл болгосон сурах бичиг, гарын авлага, лекцийн хичээлийн үзүүлэн, оюутны мэдлэг дүгнэх багц материал г.м сургалтын материалыг заадаг хичээл бүрээр бэлтгэсэн байдал	10
2	Сургалтын технологийг шинэчлэх, оюутны бие даасан ажиллагааг идэвхжүүлэх, удирдах талаар санаачилж хийсэн ажил, түүний үр дүн, нотлох баримт	10
3	Шинээр зааж байгаа лекц, боловсруулсан лаборатори, дадлагын хичээлийн хөтөлбөр, тодорхойлолт	10
4	Өөрийн удирдаж байгаа судалгааны сэдэв, захиалгат болон гэрээт эрдэм шинжилгээний ажилд магистр, докторын оюутныг оролцуулсан байдал, тэдний судалгааны ажлыг удирдсан байдал	10
5	Дангаараа болон бусадтай хамтран хийж байгаа судалгааны семинар, түүнд хамрагдагчдын тоо, хамрах хүрээ	10
6	Сургалтын чанарын баталгаажуулалтыг хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан, үр дүнг нотлох баримт	10
Нийт		60

НЭМЭЛТ ТАЙЛБАР:

“Оны шилдэг судлаач багш”-д нэр дэвшигчийн ажлыг үнэлэх шалгуур үзүүлэлт

№	Шалгаруулах болзол	Үнэлгээ
1	Нийтлүүлсэн эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн үзүүлэлт	10
2	Олон улсын хамтарсан төсөл, улсын захиалгат төсөл, суурь судалгааны сэдэвт ажил гүйцэтгэж байгаа байдал хэрэгжилт, үр дүн	10
3	Олон улсын хуралд оролцож, илтгэл хэлэлцүүлсэн байдал, үр дүн	10
4	Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, практикт нэвтрүүлсэн байдал, түүний баталгаажуулалт	10
5	Гадаадын их, дээд сургууль, шинжлэх ухааны болон олон улсын байгууллагаас хүртсэн шагнал/гэрчилгээний хуулбар	10
6	Шинээр байгуулсан лаборатори	10
	Нийт	60

НЭМЭЛТ ТАЙЛБАР:

"Оны шилдэг залуу багш"-д нэр дэвшигчийн ажлыг үнэлэх шалгуур үзүүлэлт

№	Шалгаруулах болзол	Үнэлгээ
1	Сургалт, судалгааны ажлын гол үзүүлэлт, хүрсэн үр дүн	10
2	Мэргэжил, гадаад хэл, мэдээлэл технологийн мэдлэг, чадвараа дээшлүүлэх талаар олсон амжилт	10
3	Сургалтын дэвшилтэт тэргүүний арга барил эзэмших, сургах үр чадвараа дээшлүүлэх талаар хийсэн ажил	10
4	Эрдэм шинжилгээний ажлын тодорхой чиглэл сонгон ажиллаж, үр дүнд хүрч байгаа байдал	10
5	Олон нийтэд болон оюутны дунд мэргэжлээ сурталчлах, оюутныг дагалдуулан сургах, тэдний бие даасан үйл ажиллагааг дэмжих талаар санаачлан хийсэн ажил	10
Нийт		50

НЭМЭЛТ ТАЙЛБАР:

"ХҮНДЭТ ЖУУХ"-д нэр дэвшигчийн ажлыг үнэлэх шалгуур үзүүлэлт

№	Шалгаруулах болзол	Үнэлгээ
1	Эрхэлсэн ажилдаа тогтвор суурьшилтай, идэвхи санаачлагатай, 6-аас доошгүй жил ажилласан байх	10
2	Ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг бүрэн, чанар, хүртээмжтэй хэрэгжүүлсэн байх	10
3	Байгууллагын соёл, имижийг бүрдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан байх	10
4	Хариуцсан ажилдаа шинэ санаа, сайн туршлага нэвтрүүлж, үр дүнг тооцсан байх	10
5	Ёс зүй, харилцааны хандлагын зөрчил гаргаагүй байх	10
Нийт		50

НЭМЭЛТ ТАЙЛБАР:

"БАЯРЫН БИЧИГ"-т нэр дэвшигчийн ажлыг үнэлэх шалгуур үзүүлэлт

№	Шалгаруулах болзол	Үнэлгээ
1	Эрхэлсэн ажилдаа тогтвор суурьшилтай, идэвхи санаачлагатай, 3-аас доошгүй жил ажилласан байх	10
2	Ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг бүрэн, чанар, хүртээмжтэй хэрэгжүүлсэн байх	10
3	МУИС болон бусад байгууллага, нэгжээс зохион байгуулсан ажилд идэвхтэй оролцож, амжилт гаргасан байх	10
4	Хариуцсан ажилдаа шинэ санаа, сайн туршлага нэвтрүүлж, үр дүнг тооцсан байх	10
5	Ёс зүй, харилцааны хандлагын зөрчил гаргаагүй байх	10
Нийт		50

НЭМЭЛТ ТАЙЛБАР:



МУИС-ийн оны Шилдэг оюуны өмч шалгаруулах үнэлгээний үзүүлэлт

Шинжээчийн нэр, байгууллага, албан тушаал:.....

Регистрийн дугаар.....

Дансны дугаар.....

Банкны нэр.....

Холбогдох цахим мэйл хаяг, гар утасны дугаар.....

Д/Д	Дүгнэх үзүүлэлт	Дээд оноо	Өгөх оноо	Тайлбар
	Оюуны өмчийн бүртгэлийн дугаар			
1	Тухайн оюуны өмчийн нийгэм, эдийн засгийн ач холбогдол	4		
2	Тухайн оюуны өмчийг МУИС-ийн нэр дээр бүртгүүлж авсан эсэх	4		
3	Оюуны өмчийг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн эсэх эсвэл үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж	2		